

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Политехникийн коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2023/237/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Арвайхээр хот 2023 он	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



МОНГОЛЫН УЛСЫН ТӨСВИЙН АУДИТОРЫН БАТАЛСАН ЖУРАМ

ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖ  
ЗАХИРАЛ С САНЧИР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Политехникийн коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Политехникийн коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн захирагч нь 2022 онд улсын төсвөөс 2703833.1 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдсанаас 2629890.4 мянган төгрөг зарцуулж 73942.7 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Харин орон нутгийн төсвөөс 767223.2 мянган төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсанаас 764773.0 мянган төгрөг зарцуулж 2450.2 мянган төгрөг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Гэр бүл хүүхэд залуучуудын газраас хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулан хүүхэд хөгжлийн танхимын засвар хийх зардалд 1680.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 300.0 мянган төгрөг, Дээд шатны төсвийн захирагчаас 34820.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 50893.4 мянган төгрөгийн орлого, санхүүжилт авч 84416.3 мянган төгрөгийг зарцуулж 3277.1 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх өр төлбөр өмнөх оноос 64371.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн төсвөөс байр ашиглалтын зардал болох түлш халаалтын зардлын эх үүсвэрийг дутуу тооцоолж олгосонтой холбоотой байна.

015030822

D:\New Volume 2023 on-Bichig\khereg\A4

### Аудитын гол асуудал

Тус коллеж нь Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам, дүрэмд өөрчлөлт орж гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжилтэй холбоотой УСНББОУС-17-ын дагуу үндсэн хөрөнгийг шилжүүлэн авахад өртөг, хуримтлагдсан элэгдлээр нэмэгдүүлэх, УСНББОУС-12-ын дагуу бараа материалыг шилжүүлэн авахад үнэгүй бараа материалын орлогод бүртгэх, УСНББОУС-3 дагуу авлаг, өглөг, Засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд тохируулах, Мөнгөн гүйлгээний тайланд шилжиж ирсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө буюу 1200047 дансанд бүртгэх, Өмчийн өөрчлөлтийн тайланг дансны ангиллын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд бүртгэх зэрэг чиглэлийн дагуу санхүүгийн тайланд өөрчлөлт орсон байна.

### Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудитын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О БАТЖАРГАЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### Санхүүгийн байдлын тайлан

Эргэлтийн хөрөнгийн дүн	296,010.8	351,992.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,820,937.0	11,111,062.3
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>12,116,947.7</b>	<b>11,463,055.1</b>
Нийт өр төлбөрийн дүн	-	64,371.0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	12,116,947.7	11,398,684.1
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>12,116,947.7</b>	<b>11,463,055.1</b>

### Санхүүгийн үр дүнгийн тайлан

Үйл ажиллагааны орлогын дүн	5,106,283.2	15,699,492.4
Үйл ажиллагааны зардлын дүн	3,891,130.2	4,300,808.3
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>1,215,253.6</b>	<b>11,398,684.1</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>1,215,253.6</b>	<b>11,398,684.1</b>

### Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,901,694.1	-
Тайлант оны үр дүн	1,215,253.6	11,398,684.1
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>12,116,947.7</b>	<b>11,398,684.1</b>

### Мөнгөн гүйлгээний тайлан

Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,218,545.1	3,558,749.7
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,193,474.7	3,516,759.3
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>25,070.4</b>	<b>41,990.4</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(25,070.4)</b>	<b>(41,990.4)</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>-</b>
Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### Төсвийн гүйцэтгэлийн тайлан

<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>2,411,724.0</b>	<b>3,394,663.4</b>
Урсгал зардал	2,411,724.0	3,394,663.4
Хөрөнгийн зардал	-	-
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>2,023,510.4</b>	<b>3,419,056.8</b>
Улсын төсвөөс санхүүжих	1,968,764.2	2,629,890.5
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 1 алдаа, 1 зөрчил илэрсэн.

#### Илрүүлэлт:

1. Тайлант онд 24135.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 -д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### Шийдвэрлэлт:

Албан шаардлага

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Политехникийн коллеж	1	23.9			1	23.9	1	23.9				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>23.9</b>			<b>1</b>	<b>23.9</b>	<b>1</b>	<b>23.9</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Политехникийн коллеж	1	24.1			1	24.1						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>24.1</b>			<b>1</b>	<b>24.1</b>						

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/ сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудитад ха	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Сэнэл дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>		1			1			

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6217143681  
ИЮА0059 9044094